



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 1/31

Шивээговь сум

Хариуцлагатай жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. XVII жарны "Хилэнт эх" хэмээх Модон луу жилийн Сар шинийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн харуул хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах хариуцлагатай жижүүрийг 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл томилон ажиллуулсугай.

2. Хариуцлагатай жижүүрийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар, гүйцэтгэх үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал), захирамжийн хэрэгжилтийг хангаж, хариуцлагатай жижүүрт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, удирдан зохион байгуулж, хяналт тавьж, хамтран ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Б.Шинэбаяр) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны
02 сарын 07 өдрийн 4/31 дугаар
захирамжийн 1-р хавсралт



Хариуцлагатай жижүүрийн хуваарь

2024.02.07

№	Байгууллага, албан тушаалтан	Овог нэр	Утас	Он, сар, өдөр	Цагийн хуваарь
1.	Ерөнхий боловсролын сургуулийн захирал	Д.Буяндэлгэр	99906850	2024.02.09	18 ⁰⁰ – 21 ⁰⁰
2.	ШОХК хүний нөөцийн хэлтсийн дарга	Ч.Энхжаргал	99072011		21 ⁰⁰ – 24 ⁰⁰
3.	Эрүүл мэндийн төвийн уламжлалтын их эмч	Б.Анхбаяр	88067006	2024.02.10	18 ⁰⁰ – 21 ⁰⁰
4.	“Шивээ Сервис” ХХК-ийн захирал	Ж.Чинбат	99186124		21 ⁰⁰ – 24 ⁰⁰
5.	Засаг даргын Тамгын газрын дарга	Д.Отгонжаргал	88116503	2024.02.11	18 ⁰⁰ – 21 ⁰⁰
6.	Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Гансүлд	99283933		21 ⁰⁰ – 24 ⁰⁰
8.	3-р цэцэрлэгийн эрхлэгч	Б.Даваадолгор	96663805	2024.02.12	18 ⁰⁰ – 21 ⁰⁰
9.	“Илчлэг Шивээ” ААТҮГ-ын дарга	Ш.Чинболд	96056446		21 ⁰⁰ – 24 ⁰⁰

Жич: Засаг даргын Тамгын газрын дарга сумын цагдаагийн хэсэгтэй хамтран хариуцлагатай жижүүрийн хуваарьт өдөр бүр хяналт тавьж ажиллах.

Сумын Засаг даргын 2024 оны
02 сарын 07 өдрийн А/21 тоот
захирамжийн 2-р хавсралт



**Сумын хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх удирдах албан
тушаалтнуудын үүрэг**

1. Томилогдсон хариуцлагатай жижүүрүүд 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрүүдэд 18:00 цагаас 24:00 цагийн хооронд хуваарилагдсан цагтаа үүрэг гүйцэтгэнэ.
2. Томилогдсон хариуцлагатай жижүүр нь үүрэг гүйцэтгэх цагаас 10 минутын өмнө ирж өмнөх жижүүрээс гарын үсэг зуран ажлаа хүлээн авна.
3. Хариуцлагатай жижүүрүүд утас нээлттэй байлгах, байгууллагуудтай биечлэн танилцаж үүрэг, зөвлөмж өгч холбогдох албан тушаалтан, удирдлагуудад цаг тухайд нь танилцуулж зохих арга хэмжээ авч ажиллана.
4. Хариуцлагатай жижүүрүүд хуваарийн дагуу гарч эргүүл, шалгалтын ажлыг чанартай гүйцэтгэн мэдээллийг нэгтгэн сумын Засаг даргын Тамгын газар болон Цагдаагийн хэсэгт албан ёсоор илтгэх хуудас бичиж дараагийн жижүүрт хүлээлгэн өгнө.
5. Цаг үеийн байдлыг сумын Засаг Даргын Тамгын газрын дарга Д.Отгонжаргал 88116503 дугаарт холбогдож мэдээлэл өгч ажиллана.

Шаардлагатай утасны жагсаалт:

Засаг даргын Тамгын газар - 70546809

ЗДТГ-ын Дарга – 88116503

Эрүүл мэндийн төв- 88067006

Ерөнхий боловсролын сургууль – 99906850

3-р цэцэрлэг – 96663805

“Илчлэг Шивээ” ААТҮГ – 95246417

Цагдаагийн хэсэг - 99595934